



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 9/292

Хэрлэн сум

“Амны хөндийн эрүүл мэнд” сургалт,
өдөрлөгт хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны 6 дугаар тогтоолын хавсралтын 2.1.6, 2023 оны 3 дугаар сарын 09-ний “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” арваннаймдугаар хуралдааны 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл Ирээдүй” арга хэмжээний хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Этүгэн их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн багш нартай хамтран сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нар болон эцэг, эх, асран хамгаалагчдад зориулсан “Амны хөндийн эрүүл мэнд” сэдэвт сургалт, өдөрлөгийг зохион байгуулахад 2,890,000 (хоёр сая найман зуун ерэн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Эрүүл ирээдүй” арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 11-ны өдрийн
0/292 дугаар захирамжийн хавсралт

ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

№	Зардалын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Сургагч зардал багшийн	1 багш 4 цагийн лекц (АУ-ны доктор, профессор)	320,000	1,280,000
2		1 багш 4 цагийн лекц (Хүүхдийн нүүр амны их эмч)	90,00	360,000
3	Цэцэрлэг ажиллах төлбөр дээр ажлын	10 цаг	100,000	1,000,000
Нийт дүн				2,890,000